



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/047/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453317, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Авирмэд Утас: 70453317 Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Ц.ЦЭЦЭГМАА ТАНАА

2026.02.24 № УВА-2026/047/НА-СТА-ТЦ13
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050272

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4689344.44	4859344.44
35	БАРАА МАТЕРИАЛ	4689344.44	4859344.44
354	Хангамжийн материал	4689344.44	4859344.44
35410	Бичиг хэргийн материал	122500.00	122500.00
35420	Аж ахуйн материал	874960.00	1044960.00
35470	Бусад хангамжийн материал	3691884.44	3691884.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	88659790.79	75177411.76
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	88659790.79	75177411.76
392	Биет хөрөнгө	88659790.79	75177411.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	112712636.00	80000000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-52712636.10	-28000000.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118574502.61	97520794.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-90401044.72	-74413381.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15766816.00	13872748.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15280483.00	-13802748.18
39301	Програм хангамж	450000.00	0.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450000.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	93349135.23	80036756.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	6000000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	6000000.00
413	Өглөг	0.00	6000000.00
4136	Бусад өглөг	0.00	6000000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	3300000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	2700000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	93349135.23	74036756.20
51	Засгийн газрын хувь оролцоо	93349135.23	74036756.20
512	Хуримтлагдсан үр дүн	93349135.23	74036756.20
51210	Өмнөх үеийн үр дүн	115851382.27	93349135.23
51220	Тайлант үеийн үр дүн	-22502247.04	-19312379.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	93349135.23	80036756.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	458791964.50	447774602.00
11	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	680000.00	4875000.00
120	Нийтлэг татварын бус орлого	680000.00	4875000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	4495000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	680000.00	380000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458111964.50	442899602.00

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	241405400.00	251327200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	241405400.00	251327200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	216706564.50	191572402.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25103341.00	10758200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	191603223.50	180814202.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	481294211.54	467086981.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	481294211.54	467086981.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456707265.11	455103953.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261513044.89	268973881.00
210101	Үндсэн цалин	100041811.00	109382783.00
210102	Нэмэгдэл	57720787.89	59689698.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17055000.00	21675000.00
210104	Урамшуулал	17527100.00	11293800.00
210105	Гэрээт ажлын хөлс	69168346.00	66932600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31979883.98	32929511.55
210201	Тэтгэврийн даатгал	22116382.26	22890900.37
210202	Тэтгэмжийн даатгал	2634930.45	2724916.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1025777.04	1034614.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1015132.41	1034614.65
210205	Эрүүл мэндийн даатгал	5187661.82	5244465.79
2104	Хангамж, бараа материалын зардал	34857948.20	31462340.00
210401	Бичиг хэрэг	5194730.00	4956550.00
210402	Тээвэр, шагахуун	24540000.00	19760000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4211918.20	5847990.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	911300.00	897800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6000000.00	5351000.00
210604	Урсгал засвар	6000000.00	5351000.00
2107	Томилолт, зочны зардал	41352000.00	22706000.00
210702	Дотоод албан томилолт	41352000.00	22706000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41255085.00	64312292.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39355234.00	63359632.00
210803	Даатгалын үйлчилгээ	881850.00	889100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	189201.00	41560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	22000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	784800.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39749303.04	29368929.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150000.00	2503000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16966660.00	6188550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22632643.04	20677379.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24586946.43	11983027.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	18981000.00	500000.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18000000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	981000.00	500000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5605946.43	11483027.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1662892.26	9881661.10
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3943054.17	1601366.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-22502247.04	-19312379.03
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-22502247.04	-19312379.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	458111964.50	442899602.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458111964.50	442899602.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	241405400.00	251327200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	241405400.00	251327200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	216706564.50	191572402.00
131103	ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25103341.00	10758200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	191603223.50	180814202.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	458111964.50	440199602.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458111964.50	440199602.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433525018.07	428216574.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261513044.89	268973881.00
210101	Үндсэн цалин	100041811.00	109573075.00
210102	Нэмэгдэл	57720787.89	59689698.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17055000.00	21484708.00
210104	Урамшуулал	17527100.00	11293800.00
210105	Гэрээт ажлын хөлс	69168346.00	66932600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31979883.98	32929511.55
210201	Тэтгэврийн даатгал	22116382.26	22890900.37
210202	Тэтгэмжийн даатгал	2634930.45	2724916.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1025777.04	1034614.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1015132.41	1034614.65
210205	Эрүүл мэндийн даатгал	5187661.82	5244465.79
2104	Хангамж, бараа материалын зардал	34308344.20	27952340.00
210401	Бичиг хэрэг	5194730.00	4956550.00
210402	Тээвэр, шатахуун	23860000.00	16080000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4211918.20	5847990.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1041696.00	1067800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6000000.00	7854000.00
210604	Урсгал засвар	6000000.00	7854000.00
2107	Томилолт, зочны зардал	41352000.00	20006000.00

210702	Дотоод албан томилолт	41352000.00	20006000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41255085.00	64312292.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39355234.00	63359632.00
210803	Даатгалын үйлчилгээ	881850.00	889100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	189201.00	41560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	22000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	784800.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17116660.00	6188550.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16966660.00	6188550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24586946.43	11983027.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	18981000.00	500000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18000000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	981000.00	500000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5605946.43	11483027.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1662892.26	9881661.10
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3943054.17	1601366.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	2700000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	2700000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	2700000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	2700000.00
220106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	2700000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-2700000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	115,851,382.27	115,851,382.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	115,851,382.27	115,851,382.27
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00

Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-22,502,247.04	-22,502,247.04
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	93,349,135.23	93,349,135.23
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	93,349,135.23	93,349,135.23
Наглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	93,349,135.23	93,349,135.23
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-19,312,379.03	-19,312,379.03
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	74,036,756.20	74,036,756.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	268,023,200.00	241,445,538.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	268,023,200.00	241,445,538.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,853,200.00	240,945,538.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,053,400.00	194,609,711.00
210101	Үндсэн цалин	102,931,700.00	109,573,075.00
210102	Нэмэгдэл	55,678,800.00	52,258,128.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,881,900.00	21,484,708.00
210104	Урамшуулал	17,561,000.00	11,293,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,506,700.00	25,143,842.90
210201	Тэтгэврийн даатгал	17,344,500.00	17,218,988.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,040,500.00	2,025,763.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,020,300.00	983,181.75
210204	Ажилгүйдлийн даатгал	1,020,300.00	983,181.75
210205	Эрүүл мэндийн даатгал	4,081,100.00	3,932,727.14
2104	Хангамж, бараа материалын зардал	5,100,000.00	4,017,340.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	1,441,550.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000,000.00	807,990.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,000.00	767,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.00	5,414,000.00
210604	Урсгал засвар	7,000,000.00	5,414,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	510,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	510,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,996,900.00	11,050,645.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,324,900.00	10,097,985.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	889,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	41,560.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,250,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,196,200.00	200,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	196,200.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,170,000.00	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,170,000.00	500,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,170,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	268,023,200.00	241,445,538.90
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	268,023,200.00	241,445,538.90
131001	Улсын төсвөөс санхүүжих	268,023,200.00	241,445,538.90
0	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	13.00	11.00
01	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
010001	Төсвийн байгууллага	1.00	1.00
02	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.00	5.00
020001	Удирдах ажилтан	1.00	1.00
020002	Гүйцэтгэх ажилтан	5.00	4.00
03	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6.0	5.0
030001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5.00	4.00
030009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	189,971,035.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	189,971,035.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	189,971,035.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	74,364,170.00
210102	Нэмэгдэл	7,431,570.00
210105	Гэрээт ажлын хөлс	66,932,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,785,668.65
210201	Тэтгэврийн даатгал	5,671,911.50
210202	Тэтгэмжийн даатгал	699,152.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	51,432.90
210204	Ажилгүйдлийн даатгал	51,432.90
210205	Эрүүл мэндийн даатгал	1,311,738.65
2104	Хангамж, бараа материалын зардал	23,935,000.00
210401	Бичиг хэрэг	3,515,000.00
210402	Тээвэр, шагахуун	15,080,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,040,000.00

210406	Бага үнэтэй, гүргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,140,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,700,000.00
210604	Урсгал засвар	2,440,000.00
2107	Томилолт, зочны зардал	19,496,000.00
210702	Дотоод албан томилолт	19,496,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,261,647.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,261,647.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,988,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,988,550.00
В	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	189,971,035.65
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	189,971,035.65
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,402,983.65
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	179,568,052.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зардалго нь Бид Монгол Улсын статистик мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчилнэ.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнд:

- Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг Үндэсний Статистикийн Хорооны баталсан буюу зөвшөөрсөн аргачлал, үзүүлэлтээр тогтоосон хугацаанд нь мэдээлэгч нараас гаргуулан хянаж, судалгаа дүгнэлт хийж Үндэсний статистикийн хороонд дамжуулж байхын зэрэгцээ орон нутагт мэдээллийн нэгдсэн сантай байна.
- Орон нутгийн статистикийн албаны бие даасан байдлыг бататган, орчин үеийн тооцоолох техник, хэрэгслээр хангаж, боловсон хүчний чадавхыг улам сайжруулна.
- Статистикийн мэдээлэл, судалгааны ажлын ил тод, үнэн бодит байдлыг хангаж, хамралтын хүрээг нэмэгдүүлэн хэрэглэгчдэд үйлчилнэ.
- Статистикийн судалгаа, шинжилгээний ажлын түвшнийг дээшлүүлж, чанарыг сайжруулна. Бүртгэл, статистикийн талаар гарсан хууль, тогтоомжуудыг нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдүүлэн хэвшил болгоно.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр,
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- Хөдөлмөр, Нийгмийн гүншлэлийн гурван талт үндэсний хоросны 2024 оны 10-р сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлс доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 4715 төгрөг буюу сард 792000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, гүүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар эйлдэглэж олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Статистикийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн цааны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,312.3 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Хүрдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	4,689.3	4,859.3	170.0
Үндсэн хөрөнгө	88,659.7	75,177.4	(13,482.3)
Нийт хөрөнгө	93,349.0	80,036.7	(13,312.3)
Өр төлбөр		6,000.0	6,000.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	93,349.1	74,036.7	(19,312.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	93,349.1	80,036.7	(13,312.3)

Үндсэн хөрөнгийн данс нь 75,177.4 мянган төгрөг болж 13,312.3 мянган төгрөгөөр буурсан нь нь элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Тайлант онд авлага үүсээгүй ба байгууллагад төлөх өглөг 3,300.0 мянга, хувь хүмүүст төлөх өглөг 2,700.0 мянган төгрөгийн өр үүссэн байна. Энэ жилийн эцсийн мал тооллогын хяналтын зардал олгох аймгийн Засаг даргын захирамж гарсан ч санхүүжилт олгогдоогүйгээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 74,036.7 мянган төгрөг болж 19,312.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 329,644.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 71,946.2 мянган төгрөгөөр бууруулж 257,698.3 мянган төгрөг анх баталсан.

Тайлант оны анх батлагдсан төсвийг өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 6,234.7 мянга, дотоодын жуулчдын түүвэр судалгааны 4,090.2 мянган төгрөгөөр нэмж 268,023.2 төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын 268,023.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, 16,696.1 мянган төгрөгийн санхүүжилт дугуу ирсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 241,445.5 мянган төгрөг буюу 92.8 хувьтай байгаа нь 16,696.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирж, үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 9,881.6 мянган төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70405-Албан ёсны статистик				
	90101-Үндсэн үйл ажиллагааны зардал	248,528.3	230,847.5	17,680.7	92.8%
2	70405-Албан ёсны статистик				
	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж	9,170.0	500.0	8,670.0	5.45%
3	70405-Албан ёсны статистик				
	81510 Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа	6,234.7	6,226.6	8,034.0	99.87%
4	70405-Албан ёсны статистик				
	81517-Статистикийн бусад тооллого судалгаа	4,090.2	3,871.3	218,8	94.65%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Статистикийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 180,814.2 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах, ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан орлого 10,758.2 мянган төгрөг, нийт 191,572.4 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 189,971.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 1,601.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав. Хүснэгт 3. Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/			
№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжтай холбоотой гарсан зардал	0	Зардал гараагүй
2	Унаа хоолны зардлын гүйцэтгэл	21,675.0	2026.01-2026.07 сар хүртэл 15.0 төгрөгөөр, 2026.08-2026.12 сар хүртэл 20.0 төгрөгөөр хоолны мөнгө олгосон.
3	Сургалт семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал	9,724.5	Улаанбаатар хот, Ховд аймагт сургалтад хамрагдсан. -Аймгийн төвд 19 сумын төрийн сангийн мэргэжилтэн, 93 багийн Засаг дарга, нийгмийн ажилтан нарт сургалт хийсэн.
4	Гадаад гомиллолт, арга хэмжээнд зарцуулсан зардал	0	Зардал гараагүй.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	0	Зардал гараагүй.
6	Байгууллагын орон тоо	6	2025 онд орон тоо буураагүй.
7	Хэслэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл	0	Зардал гараагүй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь тайлант онд Үндэсний статистикийн хорооноос зарласан тендерийн хүрээнд НИК ХХК-аас 19,760.0 мянган төгрөгийн шатах тослох материалын худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж

заасны дагуу Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дүгнэлт хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 481,294.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,812.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 3,850.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 467,086.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,670.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 3,736.6 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хэрэгэнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 166, хугацаа хоцроосон 3, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажигласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 785.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 300.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 485.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэвнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зөвшөөрсөн гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-т “аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 8.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /гэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд үүсгэгч удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчин тээвэр шатахууны зардлаас 300.0 мянган төгрөгийг хуурамч баримтаар зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль тогтоомж зөрчсөн	3	785.1	1	300.0			2	485.1				
Дүн	3	785.1	1	300.0			2	485.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Билэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Б.АВИРМЭД/

2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр